



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2024 оны 06 сарын 06 өдөр

Дугаар 256


Улаанбаатар хот

Журам батлах тухай

Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 29.8-д заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1."Тэтгэврийн нөөц санд хөрөнгө төвлөрүүлэх, бүртгэх, хуваарилах, байршуулах, мэдээлэх, хөрөнгө оруулах, өвлүүлэх, хяналт тавих журам"-ыг хавсралт ёсоор баталсугай.

2.Журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Х.Булгантуяад, хэрэгжилтийг хангаж ажиллахыг Нийгмийн даатгалын ерөнхий газар (Л.Мөнхзул)-т тус тус үүрэг болгосугай.



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД

ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН
ХАМГААЛЛЫН САЙД

Л.ОЮУН-ЭРДЭНЭ

Х.БУЛГАНТУЯА

Засгийн газрын 2024 оны 06 дугаар
сарын 06-ны өдрийн 256 дугаар
тогтоолын хавсралт

ТЭТГЭВРИЙН НӨӨЦ САНД ХӨРӨНГӨ ТӨВЛӨРҮҮЛЭХ, БҮРТГЭХ,
ХУВААРИЛАХ, БАЙРШУУЛАХ, МЭДЭЭЛЭХ, ХӨРӨНГӨ ОРУУЛАХ,
ӨВЛҮҮЛЭХ, ХЯНАЛТ ТАВИХ ЖУРАМ

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1.Тэтгэврийн нөөц санд хөрөнгө төвлөрүүлэх, бүртгэх, хуваарилах, байршуулах, мэдээлэх, хөрөнгө оруулах, өвлүүлэх, хяналт тавихад энэ журмыг баримтална.

Хоёр.Тэтгэврийн нөөц санд хөрөнгө төвлөрүүлэх

2.1.Нийгмийн даатгалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага (цаашид “Нийгмийн даатгалын ерөнхий газар” гэх) нь энэ журмын дагуу Төрийн сан болон Банкны тухай хуулийн 3.1.20-д заасан арилжааны банканд тэтгэврийн нөөц сангийн хөрөнгө төвлөрүүлэх данстай байна.

2.2.Энэ журмын 2.1-д заасан тэтгэврийн нөөц сангийн дансанд Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 29.3-т заасан орлогыг төвлөрүүлнэ.

2.3.Энэ журмын 2.2-т заасан орлогыг дараах байдлаар тэтгэврийн нөөц сангийн дансанд шилжүүлнэ:

2.3.1.Нийгмийн даатгалын ерөнхий газар Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 29.3.1-д заасан тухайн сарын шимтгэлийн орлогыг дараа сарын 15-ны өдрийн дотор;

2.3.2.санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага (цаашид “Сангийн яам” гэх) нь Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 29.3.2-т заасан орлогыг тэтгэврийн нөөц санд хуваарилах Засгийн газрын шийдвэр гарснаас хойш ажлын 14 өдрийн дотор.

2.4.Ажил олгогч, даатгуулагч энэ журмын 2.3.1-д заасан шимтгэлийн орлогыг төлсөн эсэхээс хамаарч дараах байдлаар шимтгэлийн орлогыг тэтгэврийн нөөц санд төвлөрүүлнэ:

2.4.1.ажил олгогч, даатгуулагч тэтгэврийн даатгалын шимтгэлээ тухайн сард багтаан бүрэн төлсөн буюу шимтгэлийн өргүй бол тэтгэврийн нөөц санд бүрэн төвлөрүүлнэ;

2.4.2.ажил олгогч, даатгуулагч тэтгэврийн даатгалын шимтгэлээ тухайн сард багтаан дутуу төлсөн буюу тайлангаар шимтгэлийн өглөгтэй гарсан тохиолдолд ажил олгогчийн төлбөл зохих тэтгэврийн даатгалын шимтгэлийн хэдэн хувийг төлснөөс тооцон тэтгэврийн нөөц санд тухайн хувиар тооцон төвлөрүүлнэ;

2.4.3.ажил олгогч, даатгуулагч тэтгэврийн даатгалын шимтгэлээ тухайн

2.4.4.ажил олгогч, даатгуулагч тэтгэврийн даатгалын шимтгэлийн өглөгийг бүрэн, эсхүл дутуу төлсөн шимтгэлийг нөхөн төлсөн бол шимтгэлээ төлсөн тухайн сард нь тэтгэврийн нөөц санд нөхөн төвлөрүүлнэ.

2.5.Сайн дураар даатгуулагч энэ журмын 2.3.1-д заасан шимтгэлийг нийгмийн даатгалын байгууллагатай гэрээгээр тохирсон хугацаанд төлсөн эсэхээс хамааруулан дараах байдлаар шимтгэлийг тэтгэврийн нөөц санд төвлөрүүлнэ:

2.5.1.сайн дураар даатгуулагч тэтгэврийн даатгалын шимтгэлээ урьдчилан төлсөн бол сар сард нь ногдох шимтгэлийг тухайн сард нь тэтгэврийн нөөц санд төвлөрүүлнэ;

2.5.2.сайн дураар даатгуулагч тэтгэврийн даатгалын шимтгэлээ тухайн сард нь төлөөгүй бол тэтгэврийн нөөц санд төлөгдөөгүй шимтгэлийг төвлөрүүлэхгүй;

2.5.3.сайн дураар даатгуулагч тэтгэврийн даатгалын шимтгэлээ нөхөн төлсөн бол нөхөн төлсөн тухайн сард нь тэтгэврийн нөөц санд нөхөн төвлөрүүлнэ.

Гурав.Тэтгэврийн нөөц сангийн хөрөнгийг бүртгэх,
хуваарилах, даатгуулагчид мэдээлэх

3.1.Нийгмийн даатгалын ерөнхий газар тэтгэврийн нөөц сангийн дансанд төвлөрсөн хөрөнгийг даатгуулагч бүрээр, түүний овог, нэр, иргэний бүртгэлийн дугаараар бүртгэнэ.

3.2.Энэ журмын 2.3.1-д заасан шимтгэлийн орлогыг ажил олгогч, даатгуулагчийн төлсөн шимтгэлд үндэслэн бүртгэнэ.

3.3.Энэ журмын 2.3.2-т заасан орлогыг Засгийн газраас тогтоосон хэмжээнд үндэслэн даатгуулагч бүрээр хуваарилан бүртгэнэ.

3.4.Тэтгэврийн нөөц сангийн хөрөнгийн өмчлөгч нь энэ журмын 3.1-д заасан даатгуулагч байх бөгөөд түүний хөрөнгийг итгэмжлэн удирдах этгээд нь Нийгмийн даатгалын ерөнхий газар байна.

3.5.Тэтгэврийн нөөц сангийн хөрөнгийг санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулсны өгөөжийг тухай бүр даатгуулагч бүрээр хуваарилж, бүртгэнэ.

3.6.Ажил олгогч, даатгуулагч энэ журмын 2.3.1-д заасан шимтгэлийг хуулиар тогтоосон хугацаанд төлөөгүй тохиолдолд нөхөн төлөх шимтгэлийг тооцох цалин хөлс, түүнтэй адилтгах орлогод Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 24.2-т заасны дагуу итгэлцүүр хэрэглэх бөгөөд уг орлогод ногдуулан төлсөн шимтгэлээс тэтгэврийн нөөц санд шимтгэлийг бүртгэнэ.

3.7.Тэтгэврийн нөөц сангийн хөрөнгийг бүртгэхдээ нийгмийн даатгалын шимтгэл төлөх, тэтгэвэр, тэтгэмж тогтооход баримтлах сарын цалин хөлс, түүнтэй адилтгах орлогын дээд хэмжээг баримтална.

3.8.Нийгмийн даатгалын ерөнхий газар хөрөнгө итгэмжлэн удирдах этгээдийн хувьд тэтгэврийн нөөц сан дахь хөрөнгийн бүртгэл, хөрөнгө оруулалт, өгөөжийн талаарх мэдээллийн системийг бүрдүүлж, даатгуулагчид энэ журмын 1 дүгээр хавсралтаар баталсан маягтын дагуу цахимаар мэдээлнэ.

Дөрөв.Тэтгэврийн нөөц сангийн хөрөнгийг
санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулах

4.1.Даатгуулагчийн тэтгэврийн нөөц санд хуримтлуулсан хөрөнгө, уг хөрөнгийг санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулсны өгөөж нь даатгуулагчийн өмч байна.

4.2.Тэтгэврийн нөөц сангийн хөрөнгийг Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 29.5-д заасны дагуу даатгуулагчийн саналд үндэслэн санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулна.

4.3.Энэ журмын 4.2-т заасан хөрөнгө оруулалтын үйл ажиллагааг Нийгмийн даатгалын ерөнхий газар хэрэгжүүлнэ.

4.4.Даатгуулагч энэ журмын 4.2-т заасан санхүүгийн хэрэгсэлд дараагийн жилд хөрөнгө оруулах хүсэлтийг тухайн жилийн 07 дугаар сарын 01-ний өдрөөс 12 дугаар сарын 01-ний өдрийг хүртэл хугацаанд энэ журмын 2 дугаар хавсралтаар баталсан маягтын дагуу цаасан болон цахим хэлбэрээр ирүүлсэн байна.

4.5.Даатгуулагч энэ журмын 4.4-т заасан хугацаанд хөрөнгө оруулалтын хүсэлтээ ирүүлээгүй бол Нийгмийн даатгалын ерөнхий газар нийгмийн даатгалын сангийн чөлөөт үлдэгдлийг санхүүгийн хэрэгсэлд оруулах шийдвэрийн нэгэн адил нөөц сангийн хөрөнгийг удирдана.

4.6.Нийгмийн даатгалын ерөнхий газар энэ журмын 4.4-т заасныг баримтлан санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулах хөрөнгийн хэмжээг тооцож, холбогдох байгууллага (Засгийн газар, Монголбанк, Сангийн яам, банкны системд нөлөө бүхий арилжааны банк)-тай гэрээ байгуулан тэтгэврийн нөөц сангийн хөрөнгийг хөрөнгө оруулна.

4.7.Нийгмийн даатгалын ерөнхий газар энэ журмын 4.6-д заасан гэрээний дагуу тэтгэврийн нөөц сангийн хөрөнгийг санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулсны өгөөжийг холбогдох гэрээнд заасан хугацаа, өгөөжийн дүнгээр тооцож, тэтгэврийн нөөц санд даатгуулагч бүрээр бүртгэнэ.

4.8.Даатгуулагч Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн 6.1.1-д зааснаар тэтгэвэр тогтоолгосон тохиолдолд түүний тэтгэврийн нөөц сангийн хөрөнгийг тэтгэврийн даатгалын санд шилжүүлнэ.

4.9.Даатгуулагч Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн 6.1.2-т зааснаар тэтгэвэр тогтоолгосон тохиолдолд түүний тэтгэврийн нөөц сангийн хөрөнгийн үлдэгдлийг түүний нэрийн дансны үлдэгдэл дээр нэмж тэтгэвэр тогтоох бөгөөд тэтгэврийн нөөц сангийн хөрөнгийг тэтгэврийн даатгалын санд шилжүүлнэ.

4.10.Даатгуулагч энэ журмын 3.8-д заасан мэдээллийн системээр хөрөнгө оруулах хүсэлт гаргах, хүсэлтийн явцын талаарх мэдээлэл, тэтгэврийн нөөц санд хуримтлуулсан хөрөнгө, уг хөрөнгийг санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулсны өгөөжийн талаарх мэдээллийг авах, шалгах эрхтэй.

Тав.Тэтгэврийн нөөц сангийн хөрөнгийг
өвлүүлэх, шилжүүлэх

5.1.Энэ журмын 4.1-д заасан хөрөнгийг даатгуулагчид өвлүүлэх эрх Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 46.3-т заасан хугацаанаас эхлэн хэрэгжинэ.

5.2. Даатгуулагч нас барсан тохиолдолд түүний тэтгэврийн нөөц сангийн хөрөнгийг дараах байдлаар зарцуулна:

5.2.1. даатгуулагчийн асрамжид Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн 16 дугаар зүйлд заасны дагуу тэжээгчээ алдсаны тэтгэвэр авах эрхтэй гэр бүлийн гишүүн байгаа бол холбогдох хууль тогтоомжийн дагуу даатгуулагчийн хөрөнгийг тэжээгчээ алдсаны тэтгэврийн эх үүсвэрт;

5.2.2. тэжээгчээ алдсаны тэтгэвэр олгож дууссаны дараа нөөц санд хөрөнгө үлдэх бол Иргэний хуульд заасан нөхцөлийн дагуу хууль ёсоор өвлүүлэх ба өвлүүлэх хөрөнгийг тэтгэврийн нөөц санд өвлөгчийн нэр дээр шилжүүлнэ;

5.2.3. даатгуулагч өөрийн хөрөнгийг гэрээслэлээр өвлүүлэхээр шийдвэрлэсэн бол энэ журмын 5.2.1-д заасны дагуу тэжээгчээ алдсаны тэтгэврийг олгож дууссаны дараа холбогдох гэрээслэлийг хэрэгжүүлнэ.

5.3. Нийгмийн даатгалын ерөнхий газар даатгуулагчийн тэтгэврийн нөөц сангийн хөрөнгийг энэ журмын 5.2.2, 5.2.3-т заасны дагуу өвлүүлэх тохиолдолд өв нээгдсэн өдрөөс хойш нэг жил өнгөрөөгүй буюу өвлөх эрхийн гэрчилгээ олгох хугацаанд аливаа хэлбэрээр зарцуулахгүй.

5.4. Даатгуулагч нас барсан тохиолдолд Нийгмийн даатгалын ерөнхий газар өв нээгдэх хүртэлх хугацаанд даатгуулагчийн хөрөнгийг тэтгэврийн нөөц сангийн дансанд хадгална.

5.5. Даатгуулагч нас барахаас өмнө түүний тэтгэврийн нөөц сангийн хөрөнгийг санхүүгийн хэрэгсэлд байршуулсан бол санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулсан хөрөнгийг буцаан татна.

5.6. Даатгуулагч нас барсан тохиолдолд түүний асрамжид байсан гэр бүлийн гишүүн, эсхүл өвлөгч даатгуулагчийн хөрөнгийг Иргэний хууль, Нотариатын тухай хуулийн дагуу холбогдох баримт бичгийг бүрдүүлэн өвийг хүлээн авах, өвлөх хүсэлтээ харьяа нийгмийн даатгалын газарт гаргана.

5.7. Нийгмийн даатгалын ерөнхий газар нас барсан даатгуулагчийн тэтгэврийн нөөц сангийн хөрөнгийг дараах журмаар шилжүүлэн бүртгэнэ:

5.7.1. нас барсан даатгуулагчийн асрамжид тэжээгчээ алдсаны тэтгэвэр тогтоолгох эрх бүхий гэр бүлийн гишүүн байгаа бол даатгуулагчийн тэтгэврийн нөөц сангийн нийт хөрөнгийг энэ журмын 5.3-т заасныг баримтлан тэжээгчээ алдсаны тэтгэвэрт зарцуулахаар тэтгэврийн даатгалын санд шилжүүлнэ;

5.7.2. энэ журмын 5.7.1-д заасны дагуу тэжээгчээ алдсаны тэтгэвэрт зарцуулах хөрөнгийг тэтгэврийн даатгалын санд шилжүүлсэн бол даатгуулагчийн тэтгэврийн нөөц сангийн хөрөнгөөс тэжээгчээ алдсаны тэтгэвэрт зарцуулсан хөрөнгийг хасаж, үлдэгдлийг өвлөгчийн нэр дээр шилжүүлэн бүртгэнэ;

5.7.3. өвлөгч харьяа нийгмийн даатгалын газарт хүсэлт гаргаснаар нийгмийн даатгалын байгууллага нас барсан даатгуулагчийн тэтгэврийн нөөц сангийн хөрөнгийг өвлөгчийн нэр дээр шилжүүлэн бүртгэнэ;

5.7.4. нас барсан даатгуулагчийн асрамжид тэжээгчээ алдсаны тэтгэвэр тогтоолгох эрх бүхий гэр бүлийн гишүүн байгаагүй буюу энэ журмын 5.2.1-д заасан

тэжээгчээ алдсаны тэтгэвэр тогтоогдохгүй бол нийгмийн даатгалын байгууллага нь өв нээгдсэнээс хойш 1 сарын дотор даатгуулагчийн тэтгэврийн нөөц сангийн хөрөнгийг өвлөгчийн нэр дээр шилжүүлэн бүртгэнэ;

5.7.5.нас барсан даатгуулагч 2 ба түүнээс дээш өвлөгчтэй бол түүний тэтгэврийн нөөц сангийн хөрөнгийг Иргэний хуулийн 520.1, 520.2, 520.3-т заасны дагуу өвлөгчийн тоогоор тэнцүү хуваан шилжүүлэн бүртгэнэ;

5.7.6.нас барсан даатгуулагчийн тэтгэврийн нөөц сангийн хөрөнгийг өвлөх хууль ёсны өвлөгч байхгүй буюу энэ журмын 5.2-т зааснаар зарцуулахгүй бол уг хөрөнгийг тэтгэврийн даатгалын санд шилжүүлнэ.

Зургаа.Тэтгэврийн нөөц сангийн хөрөнгөд тавих хяналт

6.1.Тэтгэврийн нөөц сангийн хөрөнгийг санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулсан үйл ажиллагаанд тавих хяналтыг Нийгмийн даатгалын үндэсний зөвлөл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 13.3-т заасны дагуу олон нийтийн хяналтын зөвлөл хэрэгжүүлнэ.

6.2.Нийгмийн даатгалын ерөнхий газар тэтгэврийн нөөц сангийн хөрөнгийг санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулсан үйл ажиллагааны хагас жилийн тайланг тухайн оны 07 дугаар сарын 20-ны өдрийн дотор, жилийн эцсийн тайланг дараа оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн дотор Нийгмийн даатгалын үндэсний зөвлөл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад тус тус хүргүүлнэ.

6.3.Энэ журмыг зөрчсөн, ёс зүйн зөрчил гаргасан албан тушаалтанд холбогдох хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээлгэнэ.

Тэтгэврийн нөөц санд хөрөнгө төвлөрүүлэх, бүртгэх, хуваарилах, байршуулах, мэдээлэх, хөрөнгө оруулах, өвлүүлэх, хяналт тавих журмын 1 дүгээр хавсралт

ТЭТГЭВРИЙН НӨӨЦ САНГИЙН ХӨРӨНГИЙГ ДААТГУУЛАГЧИД
МЭДЭЭЛЭХ ХУУДАС

..... оны сарын өдөр

Даатгуулагчийн:

Эцэг/эхийн нэр:.....

Нэр:.....

Дахин давтагдашгүй дугаар:

..... оны тэтгэврийн нөөц сангийн эхний үлдэгдэл:

/төгрөгөөр/

Сар	Цалин хөлс	Нийгмийн даатгалын шимтгэлээс төвлөрүүлсэн хөрөнгө			Мөнгө-жүүлсэн орлого	Хөрөнгө оруулсан дүн	Хөрөнгө оруулалтын өгөөж	Зарлага	Нийт хөрөнгө
		Ажил олгогч	Даатгуулагч	Нийт					
А	1	2	3	4	5	6	7	8	9
1									
2									
3									
4									
5									
6									
7									
8									
9									
10									
11									
12									
Дүн									

..... оны тэтгэврийн нөөц сангийн эцсийн үлдэгдэл:

.....

Тэтгэврийн нөөц санд хөрөнгө төвлөрүүлэх, бүртгэх, хуваарилах, байршуулах, мэдээлэх, хөрөнгө оруулах, өвлүүлэх, хяналт тавих журмын 2 дугаар хавсралт

ТЭТГЭВРИЙН НӨӨЦ САНГИЙН ХӨРӨНГИЙГ САНХҮҮГИЙН
ХЭРЭГСЭЛД ХӨРӨНГӨ ОРУУЛАХ ХҮСЭЛТ

..... оны сарын өдөр

Даатгуулагчийн:

Эцэг/эхийн нэр:.....

Нэр:.....

Дахин давтагдашгүй дугаар:

..... оны тэтгэврийн нөөц сангийн эхний үлдэгдэл:

Хөрөнгө оруулалтын төрөл:

- Засгийн газрын үнэт цаас
- Монголбанкны үнэт цаас
- Төрийн сангийн хадгаламж
- Арилжааны банканд байршуулах мөнгөн хадгаламж

----o0o----